



Тадаадын цэргийн алба, амьдрал

АМЕРИКИЙН АРМИЙН ОФИЦЕР БЭЛТГЭХ, АЛБА ХААХ ТОГТОЛЦОО

Сүүлийн үед манай батлан хамгаалах салбарт хийгдэж буй өөрчлөлт, шинэчлэлт нь зөвхөн аль нэг орны туршлага буюу армийн зохион байгуулалтыг хуулах биш дэлхийн өндөр хөгжил бүхий улс орнуудын туршлагыг судалж, түүний дотроос манай орны нөхцөлд хэрэгжүүлж болох тэргүүний шилдэг санааг авахад чиглэгдэх ёстой. Үүнд туслах үүднээс АНУ-ын армийн сургалт, офицер боловсон хүчин бэлтгэх, тэдэнд тавигдах шаардлага, цол олгох журам зэргээс товч өгүүлье.

1. Офицер боловсон хүчин бэлтгэх талаар

1947 онд батлагдсан "офицеруудын тухай" хуулинд Америкийн зэвсэгт хүчнийг офицеруудаар бүрдүүлэх хэд хэдэн арга хувилбарыг тодорхойлсон байдаг. Нэг дэх нь цэргийн дээд сургуулийг /америк тэдгээрийг академи гэж нэрлэдэг/ төгсөгчид, хоёр дахь нь –энгийн сургуулийн шугамаар /РОТС систем гэдэг/ цэргийн мэргэжил эзэмшигчид, гурав дахь нь армийн богино хугацааны, офицеруудын дамжааг төгсөгчид юм. Зэвсэгт хүчний тусгай мэргэжлийн офицеруудыг /эмч, хуульч, найрал дуучид/ гэх мэт энгийн дээд сургууль төгссөний дараа тусгай бэлтгэлийн дамжаагаар сургасны эцэст элсүүлж авдаг. Түүнээс гадна урьд нь бэлтгэлд байгаа офицерууд сайн дураараар буюу дахин татагдаж жинхэнэ цэргийн алба хааж болдог. Офицеруудын бүрэлдэхүүн хүрэлцэхгүй нөхцөлд эмэгтэйчүүдийг авахыг зөвшөөрдөг. Тэд тусгайлан гаргасан жагсаалтын дагуу албан тушаалд томилогдож болно. Одоогийн байдлаар эмэгтэйчүүдийн тоо бие бүрэлдэхүүний 10 хувийг эзэлж байгаа бөгөөд зарим нь захиргааны томоохон албан тушаалд алба хааж байгаагаас арав гаруй эмэгтэй генерал байна.

Офицеруудын тухай хуулиар офицер болох хүмүүст эрэгтэй эмэгтэй болон бэлтгэгдсэн аргыг харгалзахгүйгээр доорхи шаардлагуудыг тавьдаг. Үүнд: тэд заавал АНУ-ын иргэн байх бөгөөд /гэхдээ бага албан тушаалтанд хамаагүй/ 21-ээс 27 настай зохих хэмжээний бэлтгэл эзэмшсэн, Америкийн төрийн бодлогын эсрэг дотоод гадаадын ямар нэгэн эвсэл, хөдөлгөөн, байгууллагын гишүүн бус байх ёстой.

Энд “зохих хэмжээний бэлтгэл эзэмших” гэдэг нь дээрх хуулийн дагуу юу болохыг товч тайлбарлая.

Цэргийн ямар нэгэн дээд сургуульд элсүүлж авахдаа элсэгчдээс тодорхой хэмжээний мэдлэг шаарддаг. Үүнийг дунд сургууль болон тэр тусмаа ихээхэн үнэ төлбөр нэхдэг хувийн сургуулиуд хангаж чадахгүй юм. Америкийн академид ямар хүнийг элсүүлэхийг доор өгүүлнэ.

Америкт офицеруудын ихээхэн хэсгийг энгийн их, дээд, дунд сургуулиудад бэлтгэдэг. Сургалтын төлбөр нь 6-гаас 10 мянган доллар бөгөөд зарим нэр хүндтэй сургуулийн төлбөр 20 мянган доллар ч хүрдэг.

А. Ерөнхий боловсролын сургууль дахь цэргийн бэлтгэл

Америкийн дунд сургуулиудын хөтөлбөрт цэргийн бэлтгэл заавал орсон байдаг. Олонхи сурагчид 14 наснаас эхлээд офицерын бүрэлдэхүүний бэлтгэл хүч болох “Залуу үеийн” гишүүнээр элсэнэ. Тэд тусгай хөтөлбөрийн дагуу зэвсэгт хүчний төрөл мэргэжлийн цэргийн хоёр жилийн дамжаанд сураад хоёр долоо хоногийн хээрийн гаралтаар төгсөнө. Энэ дамжааны бүх зааварлагч нар болон гишүүдийн хувцас, сурах бичгийг батлан хамгаалах яам нь хангадаг байна. Үүнээс үзэхэд офицер болох хүмүүст “зохих хэмжээний бэлтгэлийг” бүр багаас нь өгдөг системтэй гэж болно.

Америкийн “офицерын тухай” хуулийн нэг онцгой зүйл нь офицеруудын өндөр цалин хангамжтай байх эрх зүйн баталгаа болдог байдаг юм. Америкийн офицеруудын жилийн дундаж цалин нь 40-50 мянган доллар. Энэ бол өндөр мэргэжилтэй ажилчдаас даруй 2 дахин их гэсэн үг.

Б.Цэргийн дээд сургууль буюу академид офицер боловсон хүчин бэлтгэх

Америкт дээд сургууль /академи/ гурав байна. Вест-Пойнтын ерөнхий цэргийн, Аннаполисын тэнгисийн цэргийн, Колорадо-Спрингсын нисэх хүчний цэргийн дээд сургууль. Тэд жил бүр офицерын бүрэлдэхүүний 10 хувийг хангадаг байна. Зэвсэгт хүчний дээд албан тушаалд голдуу эдгээр сургуулийг төгссөн хүмүүсийг томилдог бөгөөд дивиз-армийн хүрээний дарга нарын 95 хувь нь дээрх сургуулийг төгсөгчид юм. Тиймээс ч эдгээр сургуулийг төгссөн офицеруудад гол найдлага тавьдаг байна.

Эдгээр сургуульд элсэгчид нэг хуваарьт арав түүнээс дээш хүмүүс өрсөлддөг. Сургуулийн материаллаг бааз ч орчин үеийн түвшингийн шаардлагыг хангасан байна. Жишээ нь, сонсогч болгон орчин үеийн компьютертэй байна. Төгсөгчдөд боловсролын анхны зэрэг

баклаврын диплом олгоно.

Дээрх сургуулиудад элсэх залуучуудыг /элсэлтийн нас 17-22 хүртэл/ төрөл мэргэжлийн цэргийн командлагчдын шийдвэрээр шалгалтгүй авч болох юм байна. Гэвч сургуульд элссэн сонсогч болгон төгсөж чаддаггүй. Нэгдүгээр курст орсон сонсогчдоос суралцах хугацаанд 30 хүртэл хувь нь янз бүрийн шалтгаанаас хасагддаг байна. Хууль ёсоор бол тэд сургуулиа орхих ёсгүй. Яагаад гэвэл анх тэднийг сургуульд элсэх үед уг сургуулийг төгсөөд тодорхой хугацаанд армид алба хаах амлалт авч түүнийгээ бичгээр баталгаажуулна. Тиймээс ч сургуулийн удирдлага зорилгогүй хүмүүст хий хоосон мөнгө зарахыг хүсдэггүй байна. Улсаас олгож буй дүрэмт хувцас, сурах бичиг болон бусад бүх зардлыг сонсогч өөрөө төлнө. Сонсогчдоос сургуулиа төгстөл гэрлэхгүй гэдэг амлалт авна.

Сургалтын хөтөлбөр, сурах нөхцөлийг ЗХ-ний төрөл мэргэжлийн командлагчийн удирдамжаар сургууль тус бүрд жил болгон тодорхойлдог. Гол анхаарлаа нийгэм-улс төр, байгалийн болон техникийн хичээлүүдэд хандуулдаг. Цэргийн хууль эрхийн үндсийг нэлээд сайн судлахаас гадна нисэх хүчин, тэнгисийн цэргийн дээд сургуульд хамтын гэрээний болон олон улсын эрх зүйн хичээлүүдийг үздэг. Сонсогчид өдөр бүр биеийн тамир, жагсаалын сургууль хийдэг. Тэсвэр хатуужилтай, бие чийрэг байх нь америк хүний амьдралын мөрөөдөл юм.

Ер нь Америкийн цэргийн алба хаагчдын нэг шалгуур нь гар дээр суниах явдал байдаг. Эрэгтэйчүүд 68, эмэгтэйчүүд 40 удаа тус тус завсарлахгүйгээр суниах нормтой. Тэнгисийн цэргийн дээд сургуулийн хичээлийн ердийн долоо хоногийг авч үзвэл ангид 18-20 цаг, 40 хүртэлх цагийг бие даалт, үндсэн хугацааг жагсаал, биеийн тамир /хоногийн харуул манаанд гарах/ хийхэд зарцуулдаг.

Зөвхөн жагсаал, биеийн тамирын цаг дээр л командлах ур чадвар буй болно гэж тэд үздэг, тийм учраас түүнд зориулан тусгайлан цаг гаргадаггүй. Ахлах ангийн сонсогчдыг доод ангийн сонсогчдын ахлагчаар томилох бөгөөд сонсогч тэдгээртэй ажиллах явцад дарга болох дадлага олж авна.

Нийгмийн ухааны хичээлүүдээр дэлхийн улс орнуудын түүх, эдийн засаг, газар зүйг судлахаас гадна АНУ-ын ард түмний дэвшилт уламжлалд сургана.

Сургуульд сурах хугацаанд зөвхөн офицерын анхны албан тушаалд хэрэг болох цэргийн мэргэжлийн мэдлэгийг л эзэмшиж гарна. Гэхдээ цэргийн сахилга батын үндэс, түүнийг хэвшүүлэх арга зүйг маш нарийн судалж, цэргийн дүрэм, заавар, америкийн зэвсэгт хүчин

болон холбоотон орнуудын армийн салбаруудын зохион байгуулалт, тэдгээрийн байлдааны боломжийг заавал мэдсэн байх ёстой.

Сургуулийг амжилттай төгсөгчдөд офицерын анхан шатны хоёрдугаар дэслэгч /Тэнгисийн цэрэгт-дэслэгч/ цол олгож баклаврын диплом гардуулна. Ингээд цэргийн дээд сургууль төгсөгчид ерөнхий эрдмийн дээд, цэргийн эрдмийн дунд боловсролтой болно гэсэн үг. Жил бүр дээрх гурван дээд сургууль зэвсэгт хүчинд мянга шахам залуу офицеруудыг илгээдэг.

В. Энгийн их, дээд сургуулиар офицер боловсон хүчин бэлтгэх
Жил бүр РОТС системийн хүрээнд энгийн их, дээд сургуулиуд бэлтгэл офицероор арваад мянган хүнийг төгсгөдөг.

Америкийн их, дээд сургуулиудын дэргэд 30-аас 150 хүнтэй армийн жижиг салбартай. Эдгээр салбарууд одоогийн байдлаар 300-аад дээд сургуулийн дэргэд ажиллаж байгаагаас гадна мянгаад их, дээд сургууль өөрийн хүмүүсээ эдгээр салбарт явуулан сургах боломжтой. Энэ төвд 2-4 жилийн хугацаанд цэргийн бэлтгэлийн бүрэн хөтөлбөрийг эзэмшээд офицерын эхний шатны цолны болзолыг хангаад төгсгөдөг. Одоогийн байдлаар 50-60 гаруй мянган оюутан цэргийн болон энгийн хос мэргэжил эзэмших зорилго тавиад сурч байна.

Энгийн сургуулийн оюутанд цэргийн бэлтгэлээр давхар сурахад зориулан Пентагоноос нэг хүнд ойролцоогоор 7 мянган долларын тэтгэмж олгодог юм байна. Энэ мөнгөөр тэд сургуулийнхаа төлбөрийг төлөх боломжтойгоос гадна, хэрэв сургууль төгсөөд энгийн газарт ажил олдохгүй юмаа гэхэд цэргийн албанд ажиллах бололцоотой болох юм.

Түүнээс гадна цэргийн бэлтгэлийн төгсөх ангийн /300 цаг/ оюутнуудтай армид 3-4 жил ажиллаад 2-3 жил бэлтгэл офицер байх, эсвэл үндэсний гвардид 8 жил ажиллах буюу бэлтгэлд байх гэрээ хийдэг байна.

Ер нь энгийн сургуулиудаар офицер бэлтгэх систем маш нарийн зохион байгуулалттай, материаллаг баазаар бүрэн хангагдсан, оюутнуудад ч нэлээд шаардлага тавьдаг. Үндсэн курсын эхний 2 жилд 7 хоногт 3 цагийн хичээлээс гадна хагас бүтэн сайн өдрүүдэд хээрийн гаралттай. Зуны амралтын үед бүтэн хагас сарын хугацаатайгаар цэргийн хээрийн сургалтын төвд цугларалт хийнэ. РОТС системээр мэргэжилтэн бэлтгэх асуудлыг хариуцуулахаар улсынхаа газар нутгийг 4 тойрог болгон хувааж, түүний командлагчаар генерал цолтой хүнийг ажиллуулдаг. Энэ тойргууд бригадад, бригадууд нь хэд хэдэн батальоноос бүрдэнэ.

Одоо Америкийн армийн офицеруудын бүрэлдэхүүний 40 хувь

нь ROTC системээр суралцсан офицерууд байдаг. Цаашид энэ тоог 70 хувьд хүргэхээр төлөвлөж байна.

Сүүлийн үед офицер бэлтгэх богино хугацааны курс нэлээд өргөжжээ. Энэ курсүүдэд байлдааны үед ажиллах офицерын албан тушаалтны жагсаалтын дагуу цэргийн мэргэжил эзэмшүүлнэ. Курст сурахын тулд заавал дунд боловсрол эзэмшсэн байна. Эдгээр курсэд голдуу түрүүч нар суралцдаг. Курсын хугацаа 10-аас 25 хүртэл долоо хоног.

Энгийн сургуулиар бэлдсэн буюу курсэд суралцсан офицерууд армийн бага, дунд тушаалд голдуу ажилладаг байна.

2.Армид алба хаах журам.

А. Ерөнхий журам:

Америкийн армид бүх офицерууд албан тушаал ахих эрхтэй боловч ДА ФОРМ 67-7 заавраар албан тушаал дэвших журмыг тодорхойлсон байна. Тэр журмаар бол сайн гэсэн тодорхойлолттой офицерууд цаашид мэргэжил дээшлүүлэх курст суралцах эрх олж авна. Ийм эрхийг цэргийн дээд сургууль төгссөн офицерууд гурван удаа, бусад офицерууд дөрвөн удаа өөрийн алба хаах бүх хугацаанд эдэлнэ.

Офицер болсноос хойш хоёр жилийн хугацаанд хэнийг ч тушаал дэвшүүлэхгүй. Энэ хугацаанд дээд удирдлагын зүгээс шинэ залуу офицеруудад хяналт тавих, турших журмаар ажиллуулах ба туршлагатай улирсан албаны түрүүч нар тэдэнд цэргийн амьдралын талаар багш нь байж туслах ёстой. Харин цэргийн дээд сургуулийг сайн төгссөн офицеруудыг арай дээхэн албан тушаалд томилж, гэрээгээр ажиллаж байсан, эсвэл энгийн сургуулиар офицер болсон хүмүүсийг бэлтгэлд гаргана.

Офицер болсоноос хойш 2-7 жилийн хугацааны дотор эхний удаад тушаал дэвшиж ажиллах ёстой. Офицерыг тусгай комиссын хурлаар оруулан, ажил төрөлд нь үнэлгээ өгч хэрэв шаардлага хангасан гэж үзвэл түүнийг мэргэжил дээшлүүлэх 9 сар хүртэлх хугацаатай дамжаанд суралцуулна. Хэрэв амжилттай төгсвөл түүнийг хошууч-дэд хурандаа цол олгож болох албан тушаалд томилно. Энэ албан тушаалд офицер тэтгэвэрт гарах хүртэл ажиллаж болно. Энэ тохиолдолд тэтгэвэр авч болох хугацааг хуулиар 23 жилээр тогтоосон ба харин цалингийн 50 хувьтай тэнцэх тэтгэврийг 20 жил алба хаагаад авч болох юм. Ер нь Америкийн офицерын бүрэлдэхүүний ихэнх хэсгийг энэ маягаар мэргэжил дээшлүүлэх дамжаа дүүргэсэн хүмүүс эзэлдэг. Тэд голдуу цэргийн дээд сургууль төгсөгчид ба ROTC-ийн системээр бэлтгэгдэж хэд дахин шүүгдсэн офицерууд юм. Гэхдээ ROTC

системээр офицер болсон хүмүүсийг насны хязгаараар шахаж тэтгэвэрт болон удирдлагын дээд зиндаанд гаргахаас ихээхэн болгоомжилдог.

Төрөл мэргэжлийн цэргийн команд-штабын коллеж болон зэвсэгт хүчний штабын коллежийг төгсөгчид дахин дэвшин ажиллах боломжийг олж авдаг. Жишээлбэл, хуурай замын цэргийн тийм коллеж Форт-Ливернуэртэд /Канзас муж/ байдаг. Суралцах хугацаа 10 сар. Элсэгчдийг нэгтгэлийн /дивизийн/ комиссууд шалгаруулан авч армийн командлагчаар батлуулна. Жил болгон энэ коллежийг 350 хүртэл офицерууд төгсөж, бригад, хорооны захирагчаар, эсвэл дээд штабуудад ажилтнаар томилдог байна.

Ирээдүйтэй, авьяастай офицеруудыг үндэсний цэргийн болон зэвсэгт хүчний үйлдвэрийн коллеж, тэдэнтэй дүйцэх бусад дээд шатны сургуульд суралцах боломжоор хангана. Эдгээр сургуулийг төгсөнө гэдэг бол нэг ёсондоо генералын албан тушаалд тавигдах "ногоон гэрэл" гэсэн үг юм.

Хуурай замын цэргийн коллежийг төгсөн офицеруудыг нэгтгэлийн захирагч, түүнээс дээш албан тушаалд томилох ёстой ажээ.

Б. Цэргийн цол олгох журам.

Америкийн армийн офицеруудад ээлжийн цол олгох журмыг одоо хүртэл мөрдөж буй "Офицерын тухай" хуулиар тогтоосон байгаа.

Офицерын бүрэлдэхүүнийг бага офицерууд- хоёрдугаар, нэгдүгээр дэслэгч, ахмад /усан цэрэгт дэслэгч, ахлах дэслэгч, ахмад-дэслэгч/; ахлах офицерууд -хошууч, дэд хурандаа, хурандаа /3, 2, 1-р зэргийн ахмад/; дээд офицерууд-бригадын генерал, хошууч генерал, дэслэгч генерал, армийн генерал гэж дөрвөн бүлэгт хуваана.

Эдгээр цол хашиж буй албан тушаал, аттестатчлалын комиссын дүгнэлт, зэвсэгт хүчинд ажилласан хугацааг харгалзан олгодог.

Энд нэг онцлог зүйлийг зориуд тэмдэглэхэд АНУ-ын офицеруудын цол байнгын болон түр байж болно. Түр цолыг армид алба хаасан хугацааг харгалзахгүйгээр албан тушаалын дагуу шууд олгодог. Ингэснээр тэр офицерт ихээхэн итгэл хүлээлгэж байна гэсэн үг. Гэвч эдгээр офицеруудын өмнө БХЯ байнгын цолтой офицеруудыг бодоход бага үүрэг хүлээдэг. Жишээ нь: байнгын цолтой офицерын цолыг зөвхөн Ерөнхийлөгч, эсвэл цэргийн шүүх хасах эрхтэй бол, түр цолтой офицеруудын цолыг төрөл мэргэжлийн цэргийн сайдууд олгох, бууруулах, хасах эрхтэй. Хэрэв албан тушаал буурах бол түр цолыг мөн бууруулах ба орон тооны цомхотгол явагдвал хамгийн түрүүнд түр цолтой офицеруудыг ажлаас хална.

Түр цолыг бий болгосон гол зорилго бол офицеруудыг ажилдаа

дур сонирхолтой өрсөлдөөнтэй байлгаж, тэдний нэр хүндийг өргөх асуудал мөн. Офицеруудын хувцас, гадаад үзэмжинд их анхаардаг. Тиймээс ч тэдний хувцсанд янз бүрийн шошго, тэмдэг хадах ба зарим офицерын энгэрт "Над шиг хий" гэсэн тэмдэг хүртэл байдаг. Ер нь захирагч нар заавал захирагдагсдаасаа илүү цолтой байх ёстой, тэгж байж дарга нарын нэр хүндийг өндөрт байлгана гэж үздэг. Түр олгосон цол, нэмэгдэл хангамж нь тэдгээрийг хүртсэн офицеруудад ихээхэн хариуцлага хүлээлгэхээс гадна түүнийг офицерууд өөрсдөө сайн ойлгосон байх ёстой. Түр ч гэсэн хошууч цолтой офицерууд хангамжаараа, эдлэх эрхээрээ байнгын ахмад цолтой офицеруудаас илүү учраас цолоо хадгалахын төлөө хүчин зүтгэдэг.

Байнгын цолтой офицеруудын алба хаах хугацаа нэлээд урт байна. Нэгдүгээр дэслэгч цолыг авахын тулд 3 жил, ахмад 7 жил, хошууч 14 жил, дэд хурандаа 21 жил алба хаах ёстой. Ийм хугацаа түр цолонд ч хамаардаг. Алба хаагаад заавал 2 жил болж байж нэгдүгээр дэслэгч, 4 жилийн дараа ахмад, 10 жил алба хааж хошууч, 16-аас жилийн дараа албан тушаалын түр дэд хурандаа цолыг авах жишээтэй. Хугацаанаас өмнө байнгын болон түр цолыг ямарч офицерт олгодоггүй хатуу журамтай. Албан тушаал дээшлүүлэхэд заавал алба хаасан хугацааг харгалзан дэвшүүлэх журамтай учраас албан тушаалын түр цолыг шууд олгох боломжтой байдаг.

Гэвч офицеруудын цолыг бас хэмжээ хязгааргүй олгодог юм биш. Жишээлбэл, ахлах офицеруудын тоо зэвсэгт хүчний бүх офицеруудын 31хувиас хэтрэх ёсгүй. Тийм учраас албан тушаал, албан хаасан хугацаа, сайн тодорхойлолттой байлаа ч гэсэн ээлжийн болон албан тушаалын цолыг зарим үед олгодоггүй.

Офицерын байнгын цолыг Ерөнхийлөгчийн захирамжийн дагуу олгоно. Цол авах хүмүүсийг урьдчилан тусгай комиссоор заавал оруулах ёстой. Шалгалтад орох офицеруудын нэрсийн жагсаалтыг төрөл мэргэжлээр нь гаргаж нийтэд зарлана. Нэрсийн жагсаалтыг маш нарийн дэс дугаартай гаргана. Офицерууд өөрийнхөө нэ 1йг жагсаалтын хэддүгээрт байгааг хараад цол нэмэх, албан тушаал ахихаа шууд мэдэх боломжтой учир ямар нэгэн хэл яриа гардаггүй.

Америкийн зэвсэгт хүчинд нийт мянгаад генерал, адмиралууд алба хаадаг. Генерал буюу адмирал цолыг 46-47 нас хүрсэн офицерын албанд 24-өөс дээш жил ажилласан хүмүүст олгодог. Эдгээр хүмүүс нь заавал цэргийн дээд сургууль /академи/ төгссөн байхаас гадна 23 наснаас өмнө офицер болсон байна. Арав гаруй эмэгтэй генерал, адмиралууд командын ажлаас гадна янз бүрийн удирдах газар, цэргийн сургууль болон цэргийн эрдэм шинжилгээний газруудад алба

хашиж байна. АНУ офицеруудыг заавал барьж байх зарчим хэрэглэдэггүй. Офицеруудыг тодорхой гэрээгээр ажиллуулна. Хэрэв Вест-Пойнтагийн дээд сургууль төгссөн офицер 5 жилээс доошгүй ажиллах гэрээ хийх боломжтой бол цэргийн курс төгссөн офицерууд 2-4 жил ажиллах гэрээ хийх эрхтэй. Энэ хугацаанд тэр офицерыг ирээдүйгүй гэж үзвэл хугацаа дууссаны дараа удирдлага гэрээгээ шууд цуцална.

В. Офицеруудыг чөлөөнд гаргах журам.

Офицеруудыг цэргийн жинхэнэ албанаас хоёр хэлбэрээр / өөрийн хүсэлтээр, эсвэл албан шаардлагаар/ чөлөөлж болно. Гэрээний хугацаа дууссаны дараа офицер өөрийн хүслээр чөлөөлөгдөнө. Эрүүл мэндийн байдлаар, насны хязгаар болон цэргийн цолны зэрэглэлээр алба хаах хугацаа болсон, эсвэл ээлжийн цол авахад хоёр удаа татгалзсан зэрэг шалтгаануудыг харгалзан офицеруудыг албан шаардлагаар чөлөөлнө. Офицеруудын насны дээд хязгаар 60, бригадын генерал болон хурандаагийн алба хаах дээд хугацаа 30 жил, дэд хурандаагийнх 28 жил, хошууч 21 жил, гэхдээ зарим тохиолдолд нэг удаа 5 жилээр сунгаж болно. Цэргийн сургуулийн багш нар 64 нас хүртэл алба хааж болно. Орон тоо цомхотгосон үед, эсвэл ажлаа хийж чадахгүй бол албан шаардлагаар чөлөөлж болно. Албан шаардлагад биеийн тамирт муу, хар тамхи хэрэглэдэг, 3 сар ажилдаа ирээгүй, эсвэл цэргийн шүүхээр шийтгүүлсэн гэх мэт орно.

Офицеруудын идэвхийг өрнүүлэхийн тулд янз бүрийн шагнал, хангамж хэрэглэдэг. Алба хаах нөхцөл, үзүүлсэн тодорхой амжилтад мөнгөн шагнал олгоно. "Халуун цэгүүдэд" үүрэг гүйцэтгэсний төлөө сарын цалинд 110 доллар нэмж авах жишээтэй. Түүнээс гадна сэтгэл зүйн дэмжлэг үзүүлнэ. Тухайлбал, бөмбөгдөгч онгоцны гадна талд онгоцны дарга, тоотын бүрэлдэхүүний овог нэрийг бичих, дүрэмт хувцсанд тусгай шошго хадах гэх мэт.

Зарим нэр хүндтэй офицер, генералуудыг тэтгэвэрт гарсан хойно ч харж үзэж заримыг нь батлан хамгаалах салбарын удирдах газрууд, цэргийн аж үйлдвэр, эрдэм шинжилгээний байгууллагуудад зөвлөхөөр урьж ажиллуулдаг байна. "Офицеруудын тухай" хуулийн заалтын дагуу офицер боловсон хүчнийг дээд зэргээр шалгаруулан авч, ажиллах хугацаанд нь материалын болон сэтгэл зүйн талаар дэмжлэг тусалцаа үзүүлэн, албаа чин сэтгэлээсээ хаах сонирхол төрүүлдэг байна.



**Бэлтгэсэн доктор (PhD), профессор
хурандаа А.Муратхан**